



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 23 өдөр

Дугаар 7/517

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Коронавируст (COVID-19) цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний хүрээнд хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж байгаа албан хаагчдын шатахууны зардалд аймгийн Онцгой байдлын газарт 453,000 (дөрвөн зуун тавин гурван мянга), аймгийн Цагдаагийн газарт 854,000 (найман зуун тавин дөрвөн мянга), эргүүл, постонд ажиллаж байгаа албан хаагчдын витаминжуулалтын зардалд 350,000 (гурван зуун тавин мянга), хот хоорондын авто замын халдвартгүйжүүлэлтийн эсгийний зардалд 720,000 (долоон зуун хорин мянга) төгрөг, баруун болон зүүн постонд Ipad-ны зардалд 1,260,000 (нэг сая хоёр зуун жаран мянга), төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний зардалд 19 суманд нийт 29,000,000 (хорин есөн сая) төгрөгийн шатахуун тус бүр олгосугай.

3. Дээрх зардалд нийт 32,637,000 (гучин хоёр сая зургаан зуун гучин долоон мянга) төгрөгийг гамшгаас хамгаалах, эрсдэлийг бууруулах арга хэмжээний зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

А.ИШДОРЖ



011101175